



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 08 өдөр


Дугаар 01

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн даргыг сонгох,
нарийн бичгийн даргыг томилох тухай

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 36.7 дах заалтууд, БСШУС-ын Сайдын 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/272 дугаар тушаал, ШУТИС-ийн дүрмийн 4.2 дах заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 2.7, 2.8 дах заалтууд, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн Д.Баттогтохыг сонгосугай.
2. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ШУТИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Ж.Арслан-г томилон ажиллуулсугай.





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дэх заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн “Оюутны байрны төлбөр тогтоох тухай” 2021 оны 11 тоот тогтоолын хавсралтын 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилсүгэй:

Д.д	Оюутны байр	Өрөөний багтаамж, зориулалт	Сарын төлбөрийн хэмжээ мян төг	
			Нэг оюутан	Оюутнаас авах барьцаа (жилд)
4	Оюутны Ү байр (MexTC)	4 хүний	80.0	30.0

2. Оюутны байрны орчин, нөхцөлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Т.Намнан/-д үүрэг болгосугай.

